



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 09

Даланзадгад

“Аялал жуулчлал-Өрхийн орлого” дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.”ж”, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтууд, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө” –г тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс Тогтоох нь:

1. “Аялал жуулчлал-Өрхийн орлого” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, үр дүнг тооцон, хэрэгжилтийг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын  
25-ны өдрийн 09 тоот тогтоолын  
хавсралт



## “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ- ӨРХИЙН ОРЛОГО” дэд хөтөлбөр

### 1. ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА

НҮБ-ын дэргэдэх Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын зүгээс 2017 оныг “Аялал жуулчлалыг- Бүх нийтэд” уриатайгаар угтаж дэлхийн улс орнуудын иргэдэд аялал жуулчлалын эрхэм зорилгыг ойлгуулан тэдэнд тусах ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилтыг тавиад байна.

Оросын Холбооны улс, БНХАУ-ын зүгээс Монгол оронтой хамтран “Аугаа их Цайны зам”, “Түмэн бээрийн цайны зам” төслүүдийг хэрэгжүүлэх үүднээс “Гурван улсын Цайны зам” Олон улсын нэгдсэн холбоог байгуулан ажиллаж эхлээд байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагууд анхааран харж байгаа, манай хөрш орнуудын зүгээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Цайны зам” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь “Хүрдэт агуй”, Баян-Овоо сумын нутаг дахь Шар зам хэмээх замын үлдэгдэл, мөр, Ханхонгор сумын Базарын гол дахь Шар замыг дагасан Гаалийн хорооны туурь, Булган сумын Баянзаг дахь Цайны зам - Торгон замын мөр, Хадатын рашааны Цайны бичиг зэрэг түүх, соёлын үнэт дурсгалуудыг хадгалан үлдсэн газар нутаг хамрагдаж байгаа юм.

Улсын хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар бодлогын олон баримт бичгүүд хэрэгжиж байгаагийн зэрэгцээ Үндэсний хөгжлийн цогц бодлогод аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх талаар зорилтууд дэвшүүлэгдээд байна.

БОАЖЯамнаас Монголын аялал жуулчлалын салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагыг “Улаанбаатар аялал жуулчлалын үүд хот”, түүхэн баримт, судалгаанд үндэслэсэн “Түүх - соёлын аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх үндсэн зорилтыг төлөвлөөд байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-нөөс гадна аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт “Аялал жуулчлал-өрхийн орлого” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд уг хөтөлбөр нь аялал жуулчлалын салбарын хөгжлийн чухал баримт бичиг байх болно.

Энэхүү хөтөлбөр нь аялал жуулчлалын салбараас иргэд, ААН-ийн олох орлогыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь болох бөгөөд бодлогыг зөв зохион байгуулалттай хэрэгжүүлэхийг зорьж байна.

Түүнчлэн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, малчин өрх нь жуулчин хүлээн авах, байршуулах байр болон “Монгол гэр” ажиллуулах журам боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай болно.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ, САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

#### ➤ Хөтөлбөрийн зорилго

Орон нутгийн түвшинд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, эдийн засгийн өсөлтийг хангаж төрөлжүүлэх, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын нийгэмд эзлэх байр суурь, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршиж байгаа юм.

#### Хөтөлбөрийн зорилт

1. Аялал жуулчлалын салбарын хариуцлагатай, тогтвортой байдлыг сайжруулах, жуулчдыг татах
2. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон соёлын өвийн бүс нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх

3. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны бааз, малчид, иргэдийн олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, тэдний хөгжлийг дэмжих
4. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх

➤ Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

Хөтөлбөрийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсөв
- Байгууллага, иргэдийн хандив, тусламж
- Олон улсын байгууллагын тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

**2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН**

**2.1. Аялал жуулчлалын салбарын хариуцлагатай, тогтвортой байдлыг сайжруулах, жуулчдыг татах**

- 2.1.1. Байгалийн үзэсгэлэнт газруудын замыг тэмдэгжүүлэх, түр буудаллах цэгүүдийг байгуулан жуулчдыг ая тухтай аялах нөхцлийг сайжруулах
- 2.1.2. Даланзадгад суманд жуулчдын гудамж бий болгох, хоттой танилцах аялалыг зохион байгуулах, Даланзадгад сумын аялал жуулчлалын хөтөч номыг шинээр гаргах
- 2.1.3. Орон нутагт тогтмол зохион байгуулдаг албан ёсны эвент арга хэмжээг дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, “Элсний баяр”, “Говь марофон”, “Онгийн Улаан нуурын мөсний баяр” зэрэг шинэ арга хэмжээ, “Адал явдалт аялал”, “Шувуу, зэрлэг амьтан ажиглах аялал” зэрэг тусгай сонирхлын аялалуудыг бий болгож орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх
- 2.1.4. “ITM”, “Улаанбаатар” зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаанд оролцож орон нутгаа сурталчлан, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчид, иргэдэд, нөхөрлөл, урчууд, аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх
- 2.1.5. Үндэсний соёл, өв уламжлалыг сэргээх, залуу хойч үед өвлүүлэн, хэвшүүлэх зорилгоор ардын үндэсний уламжлалт тоглоом наадгайг тогтмол, тогтсон хугацаанд зохион байгуулах, шинээр үндэсний тоглоом үйлдвэрлэгчдийг дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэх
- 2.1.6. Баян заг, Ёлын амны байгалийн тэнцвэр, унаган төрхийг сэргээн хадгалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор мэргэжлийн баг, байгууллагуудтай хамтран менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлэх

**Хүрэх үр дүн:** Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах эдийн засгийн таатай орчин нөхцөл бүрдэж, бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ төрөл нэмэгдэнэ.

**2.2. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх**

- 2.2.1. Говь гурван сайхан байгалийн цогцолцорт газрын хөтөч номыг гаргах
- 2.2.2. Тусгай хамгаалалттай газрын мэдээллийн төвүүдийг шаардлагатай техник хэрэгслээр ханган тохижуулж, үйл ажиллагааг тогтмол явуулах
- 2.2.3. Ёлын ам, Дүнгэнээ, Хонгорын гол, Мухар шивэрт, Дэмчогийн хийд, Шар цав, Хүрдэт агуй зэрэг аялал жуулчлалын гол зорих газруудад жуулчдын ая тухтай аялах нөхцлийг хангаж, стандарт шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, орчныг бүрдүүлсэн үйлчилгээний цэгүүдийг бий болгож орон нутгийн иргэд, нөхөрлөл, ТББ-ын оролцоонд түшиглэн байнгын ашиглалт, арчлалтанд оруулж эзэнжүүлэх

- 2.2.4. Тусгай хамгаалалттай газруудад зөвшөөрөгдсөн цэгээс бусад газруудад тусгай сонирхлын групп аялагчдад зориулсан хоноглох, отоглох цэгүүдийг бий болгон тэмдэгжүүлж, тохижуулах

**Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгосон байна.

**2.3. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны бааз, малчид, иргэдийн олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, тэдний хөгжлийг дэмжих**

- 2.3.1. Гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн бүтээлийг борлуулах цэгийг бий болгож аялалын маршрутанд оруулж сурталчилах, зөвшөөрөгдсөн цэгт ажиллуулах /Ёлын ам, Баян заг/
- 2.3.2. Говь нэрийг илэрхийлсэн бүтээгдэхүүн болон малын гаралтай бүтээгдэхүүнийг брэнд болгох, агро-аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх
- 2.3.3. Орон нутгийн хөтөч, орчуулагчид, гэр буудал ажиллуулагсад, жуулчны үйлчилгээний жолооч нар, таксины үйлчилгээг эрхлэгчид, морь, тэмээгээр үйлчлэгч малчид, бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудыг мэргэжлийн сургалт, хөтөлбөрөөр хангаж нэгдсэн зохион байгуулалтанд оруулан үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ олгох
- 2.3.4. Гадаад зах зээлд орон нутгийн гар урлал, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг онлайнгаар болон харилцагчаар дамжуулан борлуулах нэгдсэн онлайн сайт үйлчилгээнд хамрагдах

**Хүрэх үр дүн:** Нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох орлого нэмэгдэж амьжиргааны түвшин дээшилнэ.

**2.4. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх**

- 2.4.1. БНХАУ-ын аялагч жуулчдыг хилээр нэвтрэх, аялах виз, зочлох хоногийн асуудлыг чөлөөтэй болгох
- 2.4.2. Хил дамнасан аялалыг хөгжүүлэх зорилгоор хоёр орны аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох
- 2.4.3. "Гайхамшигийн нутаг" Өмнөговь аймгийн аялал жуулчлалын үзэсгэлэнг Даланзадгад суманд зохион байгуулж, урд хөршийн аялал жуулчлалын салбарынхныг оролцуулж уламжлал болгон тогтоох

**Хүрэх үр дүн:** Хамтын ажиллагаагаа шинэ шатанд гаргаж орон нутгийнхаа эдийн засгийн хөгжлийн боломжийг нэмэгдүүлнэ.

**3. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

**3.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар**

- 3.1.1. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төсөвт үе шаттай тусгах
- 3.1.2. Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх
- 3.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх
- 3.1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачлага, оролцоог дэмжих, идэвхжүүлэх
- 3.1.5. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх

**3.2. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар**

- 3.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, хамрагдах хүрээг тогтмолжуулах
- 3.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардагдах зардал, хөрөнгийг жил бүр төсөвт тусган батлуулах

3.2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн аймгийн ЗДТГазар болон иргэд олон нийтэд жил бүр тайлагнана.

### **3.3. Сумын ИТХ, ЗДТГазар**

3.3.1. Хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ИТХ-н тогтоол, Засаг даргын захирамжаар батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, сум орон нутгийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж буйд хяналт тавих

3.3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж зөв зохистой зарцуулах

3.3.3. Хөтөлбөрийг хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн ЗДТГазар, БОАЖГазарт хагас болон бүтэн жилээр тайлагнана.

### **3.4. Төрийн бус байгууллагын оролцоо**

3.4.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж үр дүнтэй хамтран ажиллах

3.4.2. Аялал жуулчлалын асуудлаар тодорхой төсөл, бусад арга хэмжээг бие даан болон Олон улсын бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, нутгийн иргэдийг оролцуулах

### **3.5. Аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо**

3.5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, хүрээлэн байгаа орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээ явуулах талаар төр, засгаас гаргасан бодлого, хууль тогтоомжийг судлах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцох

3.5.2. Малчид, нөхөрлөл, байгаль хамгаалах клубын гишүүдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, аялал жуулчлалын стандартыг мөрдөж төсөл боловсруулж хэрэгжүүлэх, нөхөрлөл байгууллагуудын идэвх санаачлагыг дэмжих, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх

### **3.6. Иргэдийн оролцоо**

3.6.1. Иргэд нь байгаль хамгаалал, Аялал жуулчлалын чиглэлээр гарсан төр, засгийн хууль тогтоомжийг чанд биелүүлж, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

## **4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

4.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохицуулалтыг аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хариуцаж ажиллана.

4.2. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн, үр дүнг тооцох, тайлагнах ажлыг БОАЖГазар, Говь Гурван сайхан Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, "Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо" гүйцэтгэнэ.

## **5. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр аймгийн ЗДТГазрын ХОХБТХэлтэс нэгтгэн, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт үнэлгээ хийнэ.